

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм"-ийг 2017.04.10-ны өдрийн А/14 дугаар тушаалаар баталсан. Энэ ажлын хүрээнд байгууллагын "2019 оны авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г газрын даргаар 2019.03.25-ны өдөр газрын даргаар батлуулсан.			
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Байхгүй			
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, хугацаа 1 жил Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: байхгүй			
	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт-1. Шударга байдал, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх</p> <p>Зорилт-2. Авлигыг үүсгэж болзошгүй дүрэм журмыг хянах, хариуцлагын тогтолцоо бий болгох</p> <p>Зорилт-3. Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах</p> <p>Зорилт-4. Авлигын эсрэг хууль тогтоомж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах</p>			
	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	0		
Үүнд:		Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь	
Багц 1					
Багц 2 (г.м)					
	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.			
6.	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах, сургалт зохион байгуулах</p> <p>1. Авлигатай тэмцэх газар, АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран сургалт зохион байгуулах</p> <p>Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Хашбаатараар ахлуусан ажлын хэсэг 2019.11.04-ны өдөр аймгийн залуучууд театрын дугуй зааланд төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан бөгөөд манай байгууллагаас 2 албан тушаалтан уг сургалтанд хамрагдсан.</p>			

	<p>2. Эрх бүхий албан тушаалтнуудын сургалтыг зохион байгуулсан үед хамрагдах</p> <p>Авлигатай тэмцэх газар, аймгийн Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран "Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь" сэдэвт сургалтыг аймгийн ЗДТГ-ын хурлын зааланд 2019 оны 1 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд уг сургалтанд ЭБАТ хамрагдсан. Мөн Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Хашбаатараар ахлуусан ажлын хэсэг 2019.11.04-ны өдөр аймгийн залуучууд театрын дугуй зааланд аймгийн эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулсан сургалтыг зохион явуулсан.</p> <p>ГХБХБГазарт "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм"-ийг мөрдүүлэх</p> <p>1. "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм"-ийг зөрчсөн тухай мэдээллийг санал хүсэлтийн хайрцгаар хүлээн авах</p> <p>Байгууллагын үйлчилгээний зааланд санал, хүсэлт, гомдол хүлээн авах хайрцаг ажиллаж байгаа бөгөөд 2019 онд "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм"-ийг зөрчсөн тухай мэдээлэл санал хүсэлт, гомдол ирээгүй.</p> <p>2. Зөрчлийн талаар бүртгэлийг хөтлөн, хуулийн хугацаанд шийдвэрлэх, хариуцлага тооцох, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх зөвлөмж өгч ажиллах</p> <p>Зөрчил гараагүй.</p>
<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:</p>	<p>Давхар ажил эрхлэлтийг шийдвэрлэх</p> <p>1. Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж нийт албан хаагчдад танилцуулах</p> <p>Байгууллагын албан хаагчдад Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын байрны жагсаалтыг 2019.10.22-ны өдөр танилцуулсан.</p> <p>3. Албан хаагчдын давхар ажил эрхлэлтийн судалгааг гаргуулан авч, нэгдсэн журмаар давхар ажил эрхлэх зөвшөөрөл олгох, хуулиар хориглосон давхар ажил эрхлэлтийн асуудлыг зохицуулах, үүрэг чиглэл өгөх</p> <p>Байгууллагын 18-н албан хаагчийн давхар ажил эрхлэлтийн судалгааг 2019.10.22-ны өдөр гаргуулан авч АТГ-ын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд оруулах гэсэн боловч ажиллахгүй байна. 2019 оны жилийн байдлаар давхар ажил эрхлэлт байхгүй байна.</p> <p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах</p> <p>1. Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурлан гаргах</p> <p>Хэрэгжээгүй, 2020 онд хэрэгжүүлэн ажиллана.</p> <p>2. Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэж буй албан тушаалтаны үйл ажиллагаанд хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх, бичгээр зөвлөмж өгөх</p>

	<p>Хэрэгжээгүй, 2020 онд хэрэгжүүлэн ажиллана.</p> <p>Иргэдийн өргөдөл, гомдол хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах</p> <p>1. ГХБХБГазрын чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх, сурталчилах</p> <p>2019 онд орон нутгийн ЛХА, Ди Би Эс, Аа Жи Би телевизүүдэд улсын бүртгэлийн дундын мэдээллийн сан, газрын төлбөр, хүчингүй болсон газрын талаар, газрын төлбөрийн цахим систем, татварын цахим системтэй холбогдсон байгаа талаар г.м 4 удаагийн мэдээ, мэдээллүүдийг өгөх ажлыг зохион байгуулсан.</p> <p>2. ГХБХБГ-ын www.darkhan.gazar.gov.mn сайт, 70376483 утас, санал хүсэлтийн хайрцгаар өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээлэл хүлээн авах</p> <p>Нээлттэй утсаар өнөөдрийн байдлаар давхардсан тоогоор 163 орчим иргэнд мэдээлэл зөвлөгөө болон өргөдөл хүсэлтийн хариуг өгч ажилласан байна. Мөн байгууллагын фэйсбүүк хуудсанд иргэнээс асуусан 20 асуултанд хариулт өгч ажилласан. Эдгээр асуултуудын дийлэнхийг газрын гэрээ, гэрчилгээ солиулахад бүрдүүлэх материал болон шинээр газар өмчилж авч болох эсэх, газар эзэмших, өмчлөх эрхтэй холбоотой аймгийн болон сумын засаг даргын захирамж гарсан эсэх, Дархан суманд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын хариу гарсан эсэх, газрын төлбөрийн мэдээлэл авах хүсэлт, газрын төлөв байдлын чанарын баталгааг яаж хийлгэх, Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хурал болсон эсэх талаарх асуулт эзэлж байна.</p> <p>3. Өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтнүүдийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утасны дугаар, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг www.darkhan.gazar.gov.mn Цахим хуудсанд болон ГХБХБГ-ын мэдээллийн самбарт байршуулах</p> <p>Байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/contact.php цахим хуудасны холбоо барих хэсэгт болон http://darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=11 цахим хуудасны ил тод байдал хэсэгт эдгээр мэдээллүүдийг тогтмол, мөн мэдээллийн самбарт тогтмол шинэчлэн ажиллаж байна.</p>
<p>3-р зорилтын хүрээнд:</p> <p>Хүрэх үр дүн 1:</p>	<p>АТГ-ын цахим хуудсанд үнэлгээ хийх аргачлалын дагуу Дархан-Уул аймгийн www.darkhan.gazar.gov.mn сайтыг шинэчлэн сайжруулах, холбогдох мэдээллийг оруулах</p> <p>1. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын www.darkhan.gazar.gov.mn сайтын мэдээллийг байнга шинэчлэн сайжруулах, Шаардлагатай мэдээллийг ажилтнууд байнга гаргаж өгөх</p> <p>Байгууллагын цахим хуудас www.darkhan.gazar.gov.mn болон www.facebook.com/darkhangazar фэйсбүүк хуудсанд тогтмол мэдээллүүдийг байршуулж ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 12 18-ны байдлаар 36 мэдээ мэдээллийг оруулсан. Мөн ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/156 тоот тушаалаар батлагдсан "Газар өмчлүүлэх тухай хүсэлт", "Газар эзэмших тухай хүсэлт", "Газар</p>

ашиглах тухай хүсэлт”, “Газар эзэмших эрх шилжүүлж авснаар үүсэх эрх, үүргийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл”-ийг байгууллагын цахим хуудасны Төрийн үйлчилгээ цэснээс татан авах боломжтойгоор байршуулсан.

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах

1. Сул орон тооны зар, сонгон шалгаруулалт явуулах дүрэм журам, бүрдүүлэх материал, төлбөр хураамж, холбогдох бусад мэдээллийг ГХБХБГ-ын www.darkhan.gazar.gov.mn цахим хуудас мэдээллийн самбарт байршуулах, тухай бүр шинэчлэх,

2. Сонгон шалгаруулалт явуулах талаар тухай бүр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах

Инженер хайгуул, мониторингийн мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Орхон сумын газрын даамал, Барилгын материал үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоог зарлуулахаар Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлд 2019.05.17-ны өдрийн 341 тоот албан бичгээр, мөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны Б/123 дугаар тушаалаар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын бүтэц орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан шинээр хот байгуулалтын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтний орон тоо, одоо байгаа Архив бичиг хэргийн эрхлэгч, няравын албан тушаалын ангилал өөрчлөгдөж төрийн захиргааны албан тушаал болсон, мөн суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Орхон сумын газрын даамал, Барилгын материал үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоог зарлуулахаар Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлд 2019.11.01-ны өдрийн 654 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

3. Сонгон шалгаруулалтын явуулсан тайлан, сонгон шалгаруулалтад тэнцсэн болон тэнцээгүй иргэдийн тухай мэдээллийг www.darkhan.gazar.gov.mn сайтад ГХБХБГ-ын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн түгээх

Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлөөс 2019 оны 11 сард ерөнхий шалгалтыг зохион байгуулсан бөгөөд дээрх 5-н сул орон тоонд тусгай шалгалтыг зохион байгуулахаар тов гараагүй байна.

Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаад зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх

1. Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг

www.darkhan.gazar.gov.mn цахим хуудсанд байршуулах

ГХБХБГ-аас төрийн үйлчилгээг ил тод болгох Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж тухай бүр болон сар улирал, жилийн мэдээ тайланг ГХБХБГ-ын төсвийн ил тод самбарт болон

<http://darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=64>

цахим хаягт мэдээлж байна. Мөн байгууллагын цахим хуудсанд шилэн дансны <https://www.shilendans.gov.mn/org/4211> линкийг

		<p>холбож ил тод байршуулсан.</p> <p>2. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь www.darkhan.gazar.gov.mn цахим хуудсанд болон ГХБХБГ-ын мэдээллийн самбарт байршуулна.</p> <p>Мэдээллийн ил тод байдлыг хангаж байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=64 цахим хуудсанд 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь PDF хэлбэрээр байршуулсан. Мөн байгууллагын мэдээллийн самбарт цаасан хэлбэрээр хэвлэж 2019 оны 1 улиралд байршуулсан.</p> <p>3. Төсвийн орлого /газрын төлбөрийн орлого/ бүрдүүлэлтийн талаархи мэдээллийг дээрх хэлбэрээр сурталчилах</p> <p>Байгууллагын www.darkhan.gazar.gov.mn цахим хуудасны ил тод хэсгийн үйл ажиллагааны тайланд 7 хоногийн тайлан, 1 сарын тайлан, хагас жилийн тайлан, бүтэн жилийн тайланд бүрдүүлэлтийн талаарх мэдээллийг оруулсан. Мөн байгууллагын төв хаалганы дэргэд санхүүгийн ил тод байдлын самбар ажиллуулж сар бүр орлого зардлын мэдээг тогтмол шинэчилж байршуулсан. Шилэн дансны хуулийн дагуу иргэдэд долоо хоног, сар, улирал, жилийн төсөв мөнгө хөрөнгөтэй холбоотой тушаал, төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг шинэчилж шивэн оруулж файлаар хавсаргасан.</p> <p>4. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээд /ГХБХБГ-ын албан хаагч/-ийн жагсаалтыг гаргаж дээрх хэлбэрээр байршуулах, тухай бүр шинэчлэх</p> <p>2019 онд Нийгмийн даатгалын сангаас 5490534 төгрөгийн жирэмсний болон хөдөлмөрийн чадвараа түр алдсны тэтгэмж авч 4 албан хаагчид тухай бүрт анхан шатны баримтыг үндэслэн олгосон.</p>
<p>4-р зорилтын хүрээнд:</p> <p>Хүрэх үр дүн 1:</p>		<p>Авлигатай тэмцэх, шударга ёс ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих</p> <p>Төлөвлөгөө болон түүний хэрэгжилтийг байгууллагын нийт ажилтнуудад танилцуулах</p> <p>Төлөвлөгөө болон хэрэгжилтийг байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний багаар 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор дүгнүүлж, 12 сарын 25-ны дотор багтаан байгууллагын албан хаагчдад танилцуулах ажлыг зохион байгуулна.</p> <p>1. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянах шалгах</p> <p>Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийг 2019 оны 12 сарын 18-ны байдлаар 103 мэдэгдлийг албан хаагчид гаргасан байна. АТГ-ын мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд болон бүртгэлийн дэвтэр 103 мэдэгдлийг хөтлөж ажилласан.</p> <p>2. Албан тушаалтнуудын ХАСУМ-ыг хүлээн авах, бүртгэл хөтлөх зөвлөгөө өгөх, хяналт тавих, хадгалах, мэдээлэл өгөх</p> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны Б/123 дугаар тушаалаар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын</p>

		<p>газрын бүтэц орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтыг баталсан. Тус байгууллагын Газрын удирдлагын хэлтсийн газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Барилга, хот байгуулалтын хэлтсийн барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн гэсэн хоёр албан тушаалын ангилал, зэрэглэл ТЗ-6 болж өөрчлөгдсөнтэй холбогдуулан энэ ажлын байранд одоо ажиллаж байгаа газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, мөн барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн нар нь дэвшин томилогдохоор болсонтой холбогдуулан ХАСУМ хянуулах шаардлагатайг хэлж, бүрдүүлэх материал, холбогдох мэдээллийг өгч, ХАСУМ-ийг 1 хувийг авч хавтас үүсгэн хадгалсан.</p> <p>3. ХАСУМ-ийг гаргуулан авч холбогдох материалын хамт АТГ-т хүргүүлэх, бүртгэл хөтлөх</p> <p>Дээрх нэр дэвшсэн 2 албан тушаалтнаас ХАСУМ болон холбогдох материалыг хүлээн авч бүртгэл хөтлөн, АТГ-т 2019.10.30-ны өдрийн 649 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>4. АТГ-ын Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд ХАСХОМ бусад мэдэгдэл, мэдүүлэгийг бүртгэх, шивж оруулах</p> <p>Байгууллагын ХАСХОМ гаргадаг эрх бүхий 2-н албан тушаалтны 2018 оны ХАСХОМ-ийг 2019.02.02-04ны өдөр хүлээн авч АТГ-ын мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд ХАСХОМ-ыг оруулж баталгаажуулах ажлыг хийсэн.</p> <p>АТГ-т Мэдүүлгийн бүрдүүлэлтийн тайланг гаргаж хүргүүлэх</p> <p>Аймгийн Хууль, эрх зүйн хэлтсийн ХАСХОМ хариуцсан мэргэжилтэн н.Энхсайханд 2019.02.21. №133 тоот албан бичгээр ХАСХОМ-ийн тайлангуудыг битүүмжилж хүргүүлсэн.</p>					
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Ололттой тал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд ил тод, нээлттэй байх зарчмыг барьж ажиллаж байна. 2. 2019 оны "Авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г батлуулж хэрэгжилт гаргаж холбогдох байгуулагуудад нь хүргүүлж хэвшсэн. <p>Дутагдалтай тал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын төсөвт энэ чиглэлийн зардал байдаггүй, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг. <p>Анхараах асуудлууд:</p> <ol style="list-style-type: none"> 1. 2018, 2019 онд авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурлан гаргах. 2. Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэж буй албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх, бичгээр зөвлөмж өгөх 					
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ						
9.	Төсөл,	Биелэлт	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4

	хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	дундаж						
		96.25 %	4	100%	85 %	100 %	100 %	
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ						
		... %						

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт гаргасан:

ЭБАТ:  Н.Анхбаяр

2019 оны 12 дугаар сарын 19-ны өдөр